

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

“АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуул ах хөрөнгө мян/төг	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн-контентуудыг: а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл; д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц; е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;	Баримтжуулсан байх Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Жилдээ	Тухай бүрт	-	-АТГ-аас гаргасан нийтлэл, зурагт хуудсыг байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан. Авлигатай тэмцэх газраас гаргасан 1 баннер, 1 видео бичлэгийг байгууллагын цахим хуудас, facebook хуудсанд байршуулж, 1200 иргэнд мэдээлэл хүргэсэн. -Мөн “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”-ыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, албан хаагч нарт мэдээлэл хүргэсэн. Холбоос: https://tourism.ub.gov.mn/?p=15988	90%

		1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах	Олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулж, тайланд холбогдох нотломжийг хавсаргасан байна.	Жилдээ		-Аялал жуулчлалын салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг сошиал, цахимаар дамжуулан хийлээ. "Авилгад үгүй гэж хэлцгээе" уриалгыг дэвшүүлсэн 2 төрлийн баннерийг нийслэлийн Аялал жуулчлалын газраас хөтлөн явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 31,800 иргэний бүртгэлтэй 3 төрлийн facebook группээр дамжуулан иргэдэд хүргэсэн. Мөн газрын цахим хуудас, сошиал хуудсуудаар дамжуулан 4000 иргэнд мэдээллийг түгээн ажилласан. -Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн буланг сар бүр тогтмол шинэчлэн ажиллаж байна.	100%
2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой гомдол, мэдээллийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэсэн байна.	Жилдээ		-2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар иргэдээс нийт 27 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100 хувь эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Хугацаа хэтэрсэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын тайлан мэдээг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлж, https://tourism.ub.gov.mn/ цахим хуудсан олон нийтэд нээлттэй байршуулан ажиллаж байна.	100%	
	2.2. Улс, орон нутаг,	Ил тод нээлттэй			- "Нийслэлийн бүтээн байгуулалтын 2025	100%	

		<p>гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд илтэд, нээлттэй болгох</p>	<p>мэдээлсэн байна.</p>	<p>Жилдээ</p>		<p>оны төсөл, арга хэмжээний ажлын календарьчилсан төлөвлөгөө"-нд байгууллагын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 1 багц 2 төсөл, арга хэмжээ буюу Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо "Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор, музейн барилгын зураг төсөв, цахилгааны эх үүсвэрийг ажил" тусгагдан батлагдсан.</p> <p>1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/253 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн барилгын зураг төсөв боловсруулах ажил 160,000,000 (нэг зуун жаран сая)-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар "Арколис" ХХК шалгарч зургийг гүйцэтгүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн Ерөнхий Архитектораар батлуулсан.</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/717 дугаар захирамжаар Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын цахилгааны эх үүсвэр, тохижилтын ажлын 40,000,000 (дөчин сая) худалдан авах ажиллагааг зохион байгуулж,</p>	
--	--	--	-------------------------	---------------	--	---	--

						гүйцэтгэгч байгууллагаар “Филипс гэрэлтүүлэг” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ажиллан хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан.	
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан байна.				<p>-https://www.ulaanbaatar.mn/ портал системийн “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл” цэсэд 247 иргэн, хуулийн этгээд зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлж, зөвшөөрсөн 135, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 36, судлагдаж байгаа 8, буцаагдсан 50, татгалзсан 18 төлөвтэй байна.</p> <p>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл, байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажилласан.</p> <p>-Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж www.info.shilendans.gov.mn цахим санд байгууллагын жилийн төсөв, гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг</p>	90%

						<p>тогтоосон хугацаанд байршуулан тайлагнасан. Shilen.gov.mn сайтад байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр нийт 29 төрлийн 319 мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнаж, 2025 оны III улиралын байдлаар 93% ийн үнэлгээтэй байна.</p>	
	<p>3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>				<p>-Газрын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2025 оны А/45 дугаар тушаалаар батлуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах заалтыг тусгасан.</p> <p>-Албан хаагчдын Албан тушаалын тодорхойлод авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан.</p> <p>-Тушаалын хяналтын саналын хуудсыг гаргаж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тохиолдолд тайлбар, мэдэгдэлийг гаргуулан ажиллаж байна.</p> <p>-Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн хуралдааныг 2025 оны 04 сарын 17-ны өдөр зохион байгуулж ашиглалт, эдэлгээ дууссан эд хөрөнгийг актлах тухай хэлэлцэн бүртгэлд байгаа ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй 111,542,391 төгрөгийн 333 ширхэг тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг актлуулах саналыг хүргүүлж, Нийслэлийн Өмчийн</p>	<p>100%</p>

						<p>харилцааны газрын даргын 2025 оны А/203 дугаар тушаал, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны А/34 дугаар тушаалаар эргэлтийн бус хөрөнгүүдийг акталж, 40 нэр төрлийн 268 ширхэг бараа материалыг данс бүртгэлээс хасаж, 6 нэр төрлийн 19 ширхэг эргэлтийн бус хөрөнгийг бүртгэж авсан.</p> <p>Мөн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын А/292 дугаар тушаалын дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4 пос машиныг Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээс хассан.</p>	
		<p>3.3.Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангасан байна.</p>			<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/393 дугаар захирамжаар батлагдсан "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын "Авлигын эсрэг үйл ажиллагаа"-ны 2025 оны төлөвлөгөөг 2025 оны 03-р сарын 31-ний өдөр газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ханган ажиллаж байна.</p> <p>-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг", "Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, хууль журамд нийцүүлэн томилгоо хийн</p>	70%

						<p>ажиллаж байна.</p> <p>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 6 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлсэн.</p> <p>-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн "Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн дагуу 1 албан хаагчийг албан тушаал дэвшүүлж, 1 албан хаагчийг түр орлон гүйцэтгүүлж, 1 албан хаагчийг томилон ажиллуулж байна.</p> <p>-Байгууллагын даргаас гарсан хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 61, төсөв санхүү, арга хэмжээтэй холбоотой А тушаал 47-г гаргасныг байгууллагын цахим хуудас болон шилэн данс, ublegal.mn цахим хуудсанд нээлттэй байршуулан ажилласан.</p> <p>-Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 1488 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>бичлэг оруулж 3,219,009 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Тухайлбал:</p> <p>www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 178 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 10,870,</p> <p>www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 81 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 41, 564</p> <p>https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 911 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 37,208 хандалтын тоо 3,136,805</p> <p>https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 280 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 416, хандалтын тоо 18,247</p> <p>https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 38 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 517, хандалтын тоо 11,523 байна</p>	
						<p>Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан</p>	100%
		<p>3.4.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд санал өгөх</p>	Санал өгсөн байна.				

						цагдаа-2025 арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хэрэгжүүлсэн. Жуулчид ихээр зорчдог гудамж талбай, олон нийтийн газруудад 62 оюутныг өдөр бүр ээлжээр 10:00-13:00, 13:00-17:00 цагийн хооронд эргүүлийн 32 чиглэлд ажиллуулж аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмжийг өгч, ажлын үр дүн, сахилга ёс зүйд тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж, оюутан цагдаа нараас ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 4, зөрчлийн шинжтэй 18 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 11,860 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 6,380 иргэнд хэлмэрчилэн гадаад, дотоодын нийт 18,240 хүнд үйлчилгээ үзүүлж, төрлийн 5,800 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн үеэр 380 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 93 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн.	
	3.5.Нийслэлийн захиргааны байгууллагын ажиллагаа, хүлээсэн	нутгийн үйл дүрмээр үүргийн	Биелэлтийг гаргаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.			Байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж байна.	96%

	биелэлтэд шинжилгээ, тогтмол хийх	хяналт-үнэлгээг				<p>-Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмээр хүлээсэн үндсэн 15 чиг үүргийн хэрэгжилт 2025 онд 95 хувийн биелэлттэй байна.</p> <p>-2025 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын 22 захирамжийг хяналтад бүртгэж, биелэлт 98,5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан.</p>	
	3.6.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналтыг сайжруулах	Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх.				<p>Нийслэлийн удирдах ажилтнуудын 21 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 75 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр болон ERP-ээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн тухай бүр тайлагнан ажилласан.</p>	100%
	3.7.Худалдан ажиллагааны сургалтад	авах АЗ хамрагдах	Сургалтад хамруулсан байна.			<p>"Худалдан авах ажиллагааны хөтөч сургалтын төв"-тэй хамтран 18 албан хаагчийг сургалтад хамруулж, 7 албан</p>	70%

	албан хаагчийн тоог нэмэгдүүлэх				хаагч гэрчилгээтэй болоод байна.	
	3.8.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг хангасан байна.			Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан өр, авлага үүсгээгүй бөгөөд нийт батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр нь зарцуулсан. Үүнд: Үндсэн цалин 578,061,759.06 Нийгмийн даатгалд 68,315,800.75 Байр ашиглалт 4,201,956 Хангамж, бараа материалын зардал 15,766,567 Бусдаар гүйцэтгэтгүүлэх ажил үйлчилгээ 32,041,330 байна.	100%
	3.9.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах	2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.			Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан хоёр удаагийн сургалтад 7, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 10, Ёс дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад 3, нийт 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор	100%

						20 албан хаагч хамрагдсан.	
		3.10.Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалтын талаар сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.			Тагнуулын ерөнхий газрын албан бичгийг үндэслэн газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар байгууллагын нууц хамгаалах ажилтныг шинээр томилон ажиллуулсан. Тус албан хаагчийг төрийн болон албаны нууц хамгаалах, хадгалах сургалтад ирэх онд хамруулахаар төлөвлөж байна.	70%
Хэрэгжилт							91.85%

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Ч.Ам-Очира* Ч.ЭНХ-ОТГОН


ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.Ундармаа

Ш.УНДАРМАА

Цахим хуудсуудаар түгээсэн мэдээлэл





Албан хаагч, иргэдэд тараасан материал, мэдээллийн самбар.

